ARD | ДААТГАЛ

"Ард Санхүүгийн Нэгдэл"-ийн байр 2 дугаар давхар
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот 14200, Монгол улс
Утас: 7720 0089 И-мэйл: info@arddaatgal.mn

2021 он 04 сар 28 өдөр    Дугаар 01/21    Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2021 оны 4 сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА    Ч.ГАНХУЯГ

ARD INSURANCE COMPANY
АРД ДААТГАЛ ХК
УЛААНБААТАР ХОТ

ARD | ДААТГАЛ

"Ард Санхүүгийн Нэгдэл"-ийн байр 2 дугаар давхар
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот 14200, Монгол улс
Утас: 7720 0088 И-мэйл: info@arddaatgal.mn

2021 он 04 сар 28 өдөр　　　　Дугаар 02/21　　　　Улаанбаатар хот

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2019 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссынн 21/04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Чулуун овогтой Ганхуяг, Одончимэд овогтой Одбаяр, Галбадрах овогтой Цогбадрах, Батбилэг овогтой Золбоо, Чулуун овогтой Ганзориг, Сүхдорж овогтой Оргил нарыг, хараат бус гишүүнээр Зоригт овогтой Ариун, Баатарзоригт овогтой Болорчимэг, Ичинхорлоо овогтой Сэр-Од нарыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА　　　　Ч.ГАНХУЯГ

ARD ДААТГАЛ

"Ард Санхүүгийн Нэгдэл"-ийн байр 2 дугаар давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14200, Монгол улс.
Утас: 7720 0099, И-мэйл: info@arddaatgal.mn.

2021 он 04 сар 28 өдөр

Дугаар 03/21

Улаанбаатар хот

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Дүрмийн өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 2021 оны 4 сарын сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 21/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот” гэж өөрчлөн, өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, дүрмийн өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах Хороонд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Цогбадрах)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Ч.ГАНХУЯГ